



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/325/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Санхүү-Нийцлийн аудитын хэлтсийн дарга, аудитын менежер: Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Я.Алтанцэцэг Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: М.Ундармаа Утас: 325093 Цахим хаяг: undarmaam@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024. 02. 23 № 426
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА,
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ
Б.МӨНГӨНХУЯГ ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

002829825

D:\Desktop\2024\Work\Bocad\2024\02\23.BGD.ZBTG.docx

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тайлант онд Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын тамгын газар нь байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 289 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба гүйцэтгэлийг 92.4 хувиар хэрэгжүүлсэн гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	522,556,186.32	233,420,666.11
34	УРЬДЧИЛГАА	52,307,350.32	19,175,227.12
34600	Урьдчилж гарсан зардал	7,709,931.12	7,348,012.12
34710	Урьдчилгаа тооцоо	44,597,419.20	11,827,215.00
34714	Томилолтын урьдчилгаа	44,597,419.20	11,827,215.00
35	БАРАА МАТЕРИАЛ	470,248,836.00	214,245,438.99
35400	Хангамжийн материал	470,248,836.00	214,245,438.99
35410	Бичиг хэргийн материал	25,541,049.00	16,767,120.00
35420	Аж ахуйн материал	14,141,113.00	0.00
35430	Сэлбэг хэрэгсэл	4,746,600.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	425,820,074.00	197,478,318.99
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	90,704,726,648.22	91,302,230,024.21
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	90,704,726,648.22	91,302,230,024.21
39200	Биет хөрөнгө	90,170,740,247.82	90,768,243,624.21
39201	Барилга, байгууламж, орон сууц	67,065,533,046.96	66,993,779,546.96
39202	Хуримтлагдсан элэгдэл	-22,765,306,078.60	-27,896,127,763.47
39203	Авто-тээврийн хэрэгсэл	370,318,000.00	2,521,651,331.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-266,740,299.96	-499,461,500.07
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	2,102,362,021.50	2,725,667,451.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	-971,597,993.13	-1,325,839,222.52
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,407,224,571.00	1,600,272,089.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-748,469,900.57	-893,985,763.41
39214	Бусад үндсэн хөрөнгө	56,897,233,190.54	65,139,085,937.25
39215	Хуримтлагдсан элэгдэл	-12,934,908,109.92	-17,611,890,282.03
39217	Ном	15,091,800.00	15,091,800.00
39300	Биет бус хөрөнгө	533,986,400.40	533,986,400.00
39301	Программ хангамж	4,596,000.00	4,596,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-4,595,999.60	-4,596,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	533,986,400.00	533,986,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	91,227,282,834.54	91,535,650,690.32
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	91,227,282,834.54	91,535,650,690.32
51	Засгийн газрын хувь оролцоо	91,227,282,834.54	91,535,650,690.32
51100	Засгийн газрын оруулсан капитал	26,449,980,907.16	26,449,980,907.16
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	26,449,980,907.16	26,449,980,907.16
51200	Хуримтлагдсан үр дүн	27,020,616,846.25	27,328,984,702.03
51210	Өмнөх үеийн үр дүн	17,246,823,926.18	27,020,616,846.25
51220	Тайлант үеийн үр дүн	9,773,792,920.07	308,367,855.78
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	37,756,685,081.13	37,756,685,081.13
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	91,227,282,834.54	91,535,650,690.32

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	31,626,058,020.39	30,307,231,272.22

Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18,655,506,649.69	10,824,544,075.47
120	Нийтлэг татварын бус орлого	18,655,506,649.69	10,824,544,075.47
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	24,861,160.00	17,189,960.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,145,140.00	830,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,716,020.00	16,359,960.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	18,629,942,305.57	10,798,781,805.59
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	703,184.12	8,572,309.88
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	12,970,551,370.70	19,482,687,196.75
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	252,228,370.70	217,605,991.57
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	25,846,981.71
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	56,200,000.00	125,035,292.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	196,028,370.70	66,723,717.86
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	12,718,323,000.00	19,265,081,205.18
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	12,718,323,000.00	19,265,081,205.18
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	21,811,793,101.09	29,952,163,845.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	21,811,793,101.09	29,952,163,845.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21,351,852,400.68	29,220,327,782.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,648,865,297.48	10,386,633,324.52
210101	Үндсэн цалин	2,299,190,366.54	3,417,704,063.00
210102	Нэмэгдэл	558,322,140.94	2,054,059,041.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	766,742,531.00	978,754,506.40
210104	Урамшуулал	250,315,362.00	833,239,879.52
210105	Гэрээт ажлын хөлс	1,774,294,897.00	3,102,875,834.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	762,210,100.00	1,411,838,600.00
210201	Тэтгэврийн даатгал	506,230,100.00	993,516,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	63,995,000.00	104,580,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	51,196,000.00	83,664,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	12,799,000.00	20,916,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	127,990,000.00	209,161,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	971,021,017.06	1,552,810,181.83
210301	Гэрэл, цахилгаан	157,515,207.59	256,465,360.20
210302	Түлш, халаалт	207,828,085.00	251,990,093.45
210303	Цэвэр, бохир ус	79,125,314.47	74,311,694.84
210304	Байрны түрээс	526,552,410.00	970,043,033.34

2104	Хангамж, бараа материалын зардал	420,257,461.00	561,615,429.97
210401	Бичиг хэрэг	185,504,580.00	213,694,779.00
210402	Тээвэр, шатахуун	33,315,172.00	71,440,881.88
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	101,003,521.00	101,934,519.09
210404	Ном, хэвлэл	5,850,200.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	94,583,988.00	174,545,250.00
2105	Нормативт зардал	0.00	25,203,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	25,203,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,676,866.43	421,068,683.00
210604	Урсгал засвар	500,676,866.43	421,068,683.00
2107	Томилолт, зочны зардал	216,339,829.60	331,664,828.90
210701	Гадаад албан томилолт	199,934,165.60	331,126,528.90
210702	Дотоод албан томилолт	906,000.00	0.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	15,499,664.00	538,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,332,047,966.50	2,100,132,421.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,310,976,697.50	2,078,430,488.44
210804	Тээврийн хэрэгслийн татвар	61,400.00	342,204.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,266,300.00	185,000.00
210807	Газрын төлбөр	19,743,569.00	21,174,728.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,500,433,862.61	12,429,360,813.46
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,313,055,062.02	1,911,854,609.58
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	9,187,378,800.59	10,517,506,203.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	459,940,700.41	731,836,063.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	440,085,478.99	731,836,063.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	97,076,372.00	52,447,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	343,009,106.99	679,388,563.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	19,855,221.42	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,855,021.42	0.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	200.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	9,814,264,919.30	355,067,426.50
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	40,471,999.23	46,699,570.72
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	40,471,999.23	46,699,570.72
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	9,773,792,920.07	308,367,855.78

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	12,995,412,530.70	19,499,877,156.75
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24,861,160.00	17,189,960.00
120	Нийтлэг татварын бус орлого	24,861,160.00	17,189,960.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	24,861,160.00	17,189,960.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,145,140.00	830,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,716,020.00	16,359,960.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	12,970,551,370.70	19,482,687,196.75
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	252,228,370.70	217,605,991.57
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	25,846,981.71
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	56,200,000.00	125,035,292.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	196,028,370.70	66,723,717.86
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	12,718,323,000.00	19,265,081,205.18
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	12,718,323,000.00	19,265,081,205.18
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,740,933,726.70	19,136,949,811.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,740,933,726.70	19,136,949,811.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,280,993,026.29	18,405,113,748.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,648,865,297.48	10,386,633,324.52
210101	Үндсэн цалин	2,299,190,366.54	3,417,704,063.00
210102	Нэмэгдэл	558,322,140.94	2,054,059,041.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	766,742,531.00	978,754,506.40
210104	Урамшуулал	250,315,362.00	833,239,879.52
210105	Гэрээт ажлын хөлс	1,774,294,897.00	3,102,875,834.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	762,210,100.00	1,411,838,600.00
210201	Тэтгэврийн даатгал	506,230,100.00	993,516,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	63,995,000.00	104,580,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	51,196,000.00	83,664,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	12,799,000.00	20,916,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	127,990,000.00	209,161,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	971,021,017.06	1,552,810,181.83
210301	Гэрэл, цахилгаан	157,515,207.59	256,465,360.20
210302	Түлш, халаалт	207,828,085.00	251,990,093.45
210303	Цэвэр, бохир ус	79,125,314.47	74,311,694.84
210304	Байрны түрээс	526,552,410.00	970,043,033.34

Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2104	Хангамж, бараа материалын зардал	342,605,646.00	440,914,184.09
210401	Бичиг хэрэг	126,221,400.00	165,416,925.00
210402	Тээвэр, шатахуун	22,859,720.00	23,127,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	101,003,521.00	101,934,519.09
210404	Ном, хэвлэл	5,850,200.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	86,670,805.00	150,434,940.00
2105	Нормативт зардал	4,555,000.00	1,298,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,555,000.00	1,298,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	507,926,866.43	459,936,476.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	2,398,800.00
210602	Тавилга	7,250,000.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	15,500,000.00
210604	Урсгал засвар	500,676,866.43	442,037,676.00
2107	Томилолт, зочны зардал	248,152,328.80	298,894,624.70
210701	Гадаад албан томилолт	231,746,664.80	298,356,324.70
210702	Дотоод албан томилолт	906,000.00	0.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	15,499,664.00	538,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,382,966,979.90	1,864,600,454.17
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,361,895,710.90	1,842,898,521.57
210803	Даатгалын үйлчилгээ	61,400.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,266,300.00	342,204.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	0.00	185,000.00
210807	Газрын төлбөр	19,743,569.00	21,174,728.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,412,689,790.62	1,988,187,903.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,412,689,790.62	1,988,187,903.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	459,940,700.41	731,836,063.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	440,085,478.99	731,836,063.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	97,076,372.00	52,447,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	343,009,106.99	679,388,563.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	19,855,221.42	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,855,021.42	0.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	200.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	254,478,804.00	362,927,345.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	254,478,804.00	362,927,345.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	254,478,804.00	362,927,345.00
2200	Дотоод эх үүсвэрээр	254,478,804.00	362,927,345.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	254,478,804.00	362,927,345.00

VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-254,478,804.00	-362,927,345.00
----	--	-----------------	-----------------

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	26,449,980,907.16	37,756,685,081.13	17,246,823,926.18	81,453,489,914.47
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	26,449,980,907.16	37,756,685,081.13	17,246,823,926.18	81,453,489,914.47
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	9,773,792,920.07	9,773,792,920.07
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	26,449,980,907.16	37,756,685,081.13	27,020,616,846.25	91,227,282,834.54
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	26,449,980,907.16	37,756,685,081.13	27,020,616,846.25	91,227,282,834.54
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	26,449,980,907.16	37,756,685,081.13	27,020,616,846.25	91,227,282,834.54
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	308,367,855.78	308,367,855.78
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	26,449,980,907.16	37,756,685,081.13	27,328,984,702.03	91,535,650,690.32

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	19,553,966,900.00	19,282,271,165.18	271,695,734.82	98.6%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	19,553,966,900.00	19,282,271,165.18	271,695,734.82	98.6%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	18,801,519,400.00	18,571,335,102.18	230,184,297.82	98.8%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,453,441,600.00	10,386,633,324.52	66,808,275.48	99.4%
210101	Үндсэн цалин	3,284,119,000.00	3,417,704,063.00	-	104.1%
210102	Нэмэгдэл	1,815,587,500.00	2,054,059,041.60	-	113.1%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,040,780,000.00	978,754,506.40	62,025,493.60	94.0%
210104	Урамшуулал	1,129,955,100.00	833,239,879.52	296,715,220.48	73.7%
210105	Гэрээт ажлын хөлс	3,183,000,000.00	3,102,875,834.00	80,124,166.00	97.5%

Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,411,838,600.00	1,411,838,600.00	0.00	100.0%
210201	Тэтгэврийн даатгал	993,516,100.00	993,516,100.00	0.00	100.0%
210202	Тэтгэмжийн даатгал	104,580,500.00	104,580,500.00	0.00	100.0%
210203	ҮОМШӨ-ний даатгал	83,664,400.00	83,664,400.00	0.00	100.0%
210204	Ажилгүйдлийн даатгал	20,916,100.00	20,916,100.00	0.00	100.0%
210205	Эрүүл мэндийн даатгал	209,161,500.00	209,161,500.00	0.00	100.0%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,630,583,200.00	1,552,810,181.83	77,773,018.17	95.2%
210301	Гэрэл, цахилгаан	305,199,300.00	256,465,360.20	48,733,939.80	84.0%
210302	Түлш, халаалт	283,776,300.00	251,990,093.45	31,786,206.55	88.8%
210303	Цэвэр, бохир ус	90,000,000.00	74,311,694.84	15,688,305.16	82.6%
210304	Байрны түрээс	951,607,600.00	970,043,033.34	-18,435,433.34	101.9%
2104	Хангамж, бараа материалын зардал	440,545,100.00	438,374,184.09	2,170,915.91	99.5%
210401	Бичиг хэрэг	165,431,100.00	165,416,925.00	14,175.00	100.0%
210402	Тээвэр, шатахуун	21,614,000.00	21,587,800.00	26,200.00	99.9%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	105,000,000.00	101,934,519.09	3,065,480.91	97.1%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	148,500,000.00	149,434,940.00	-934,940.00	100.6%
2105	Нормативт зардал	5,540,000.00	1,298,000.00	4,242,000.00	23.4%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,540,000.00	1,298,000.00	4,242,000.00	23.4%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	739,100,000.00	706,893,376.00	32,206,624.00	95.6%
210601	Багаж, техник, хэрэгсэл	280,000,000.00	249,355,700.00	30,644,300.00	89.1%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	15,500,000.00	15,500,000.00	0.00	100.0%
210604	Урсгал засвар	443,600,000.00	442,037,676.00	1,562,324.00	99.6%
2107	Томилолт, зочны зардал	305,538,300.00	298,894,624.70	6,643,675.30	97.8%
210701	Гадаад албан томилолт	305,000,000.00	298,356,324.70	6,643,675.30	97.8%
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	538,300.00	538,300.00	0.00	100.0%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,794,932,600.00	1,766,604,907.60	28,327,692.40	98.4%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,773,032,600.00	1,744,902,975.00	28,129,625.00	98.4%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	500,000.00	342,204.00	157,796.00	68.4%
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	200,000.00	185,000.00	15,000.00	92.5%
210807	Газрын төлбөр	21,200,000.00	21,174,728.60	25,271.40	99.9%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,020,000,000.00	2,007,987,903.44	12,012,096.56	99.4%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,020,000,000.00	2,007,987,903.44	12,012,096.56	99.4%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	752,447,500.00	710,936,063.00	41,511,437.00	94.5%
2132	Бусад урсгал шилжүүлэг	752,447,500.00	710,936,063.00	41,511,437.00	94.5%

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,447,500.00	52,447,500.00	0.00	100.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000,000.00	658,488,563.00	41,511,437.00	94.1%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	19,553,966,900.00	19,282,271,165.18	271,695,734.82	98.6%
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	19,534,966,900.00	19,265,081,205.18	269,885,694.82	98.6%
320001	Орон нутгийн төсвөөс	19,534,966,900.00	19,265,081,205.18	269,885,694.82	98.6%
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	19,000,000.00	17,189,960.00	1,810,040.00	90.5%
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	800,000.00	830,000.00	-30,000.00	103.8%
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,200,000.00	16,359,960.00	1,840,040.00	89.9%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	217,605,991.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	217,605,991.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	196,705,991.57
2104	Хангамж, бараа материалын зардал	2,540,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,540,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,700,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,900,000.00
210602	Тавилга	2,800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	179,465,991.57
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	179,465,991.57
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,900,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,900,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	217,605,991.57
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	217,605,991.57
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	25,846,981.71
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	125,035,292.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	66,723,717.86

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 229,228.5 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 82,645.2 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 146,583.3 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

3.1 Албан шаардлага

3.1.1 Оны шилдэг хэлтэс, ажилчдыг шагнахад 30,300.0 мянга, сургалтын арга хэмжээнд 3,565.0 мянган төгрөгийг нэр бүхий ажилтны хувийн данс руу шилжүүлсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах",

3.1.2 Шүүхийн шийдвэрийг үндэслэн ажил олгогчийн буруутай шийдвэрийн улмаас ажлаас халагдсаны 14,895.6 мянган төгрөгийг төсвөөс олгож, ажлаас чөлөөлсөн албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ", 103.2 "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна",

3.1.3 Анхан шатны бүрдэл дутуу баримтаар 33,884.6 мянган төгрөгийн ажил, гүйлгээ бүртгэсэн. (Төсвийн хэлэлцүүлгийн зардалд 12,054.6 мянга, удирдах ажилтны тайлангийн хуралд 16,830.0 мянга, улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд сурталчлах зардал 5,000.0 мянга) нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1."Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

3.1.4 Өмнөх оны аудитаар өгсөн 2 албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" заалтуудыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Хариуцлага тооцуулах албан шаардлага өгөв.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт: Татварын бааз суурийг нэмэгдүүлж, татварын орлого төвлөрүүлэх зорилгоор 13 ажилтныг гэрээгээр ажиллуулж 129,249.3 мянган төгрөгөөр цалинжуулсан нь төсвийг хяналтгүй, үр ашиггүй зарцуулах үр дагавар бий болгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, 16.5.3 “*батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох*” заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах, давхардуулсан цалин, урамшуулал төлөвлөхгүй байж төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар зарцуулж байх.

3.2.2 Илрүүлэлт: Гадаадын зочид төлөөлөгчдийг хүлээн авч 17,334.0 мянган төгрөгийг зарцуулж төсвийн хөрөнгийг үр ашиггүй, хяналтгүй зарцуулах үр дагавар бий болгосон. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “*үнэн зөв байх*”, 13 дугаар зүйлийн 13.1 “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*” заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн хөрөнгийг аялал, хүлээн авалтын зардалд зарцуулахгүй байх, алдааг давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчил

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нэр бүхий ажилтны хувийн данс руу шилжүүлэг хийсэн.	1	33,865.0			1	33,865.0						
Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн.	1	33,884.6			1	33,884.6						
Шүүхийн шийдвэрээр халагдсан ажилтны ажилгүй байсан хугацааны цалинг төсвөөс олгож, ажлаас чөлөөлсөн албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй.	1	14,895.6			1	14,895.6						
Өмнөх онд өгсөн 63,265.6 мянган төгрөгийн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй.	1	-							1	-		
Улсын төсвийн байгууллагын үйл ажиллагааг дэмжиж 13 ажилтныг гэрээгээр ажиллуулсан.	1	129,249.3					1	129,249.3				
Гадаадын зочид төлөөлөгчдийг хүлээн авч аяллын арга хэмжээ зохион байгуулсан.	1	17,334.0					1	17,334.0				
Дүн	6	229,228.5	0	-	3	82,645.2	2	146,583.3	1	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
250 ширхэг хуулийн эмхэтгэл ном хэвлүүлсэн.	1	4,500.0	1	4,500.0				
Бэлэг дурсгалын зүйл худалдан авсан.	1	2,091.6	1	2,091.6				
Тайлант онд байрны түрээсийн төлбөр болон гадаад албан томилолтын зардал өмнөх оноос өссөн.	1	510,100.3					1	510,100.3
900 ширхэг даавуун торыг илүү хэмжээгээр худалдан авсан.	1	5,670.0					1	5,670.0
Цасны баяр тэмдэглэж төсвийг үр ашиггүй зарцуулсан.	1	11,600.0					1	11,600.0
Нийт дүн	5	533,961.9	2	6,591.6	0	0	3	527,370.3